МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

УУЛ УУРХАЙ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ, ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЛИЙН ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Д.ЖАДАМБА

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны

Төрийн захиргааны удирдлагын газрын

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

АГУУЛГА

- Ашигт малтмалын тухай хуулийн үзэл баримтлал, өөрчлөлт, чиг хандлага
- Ашигт малтмалын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдэл
- Газрын тосны тухай хуулийн үзэл баримтлал, өөрчлөлт, чиг хандлага
- Газрын тосны тухай хуулийн давхардал, зөрчил, хийдэл
- Чиг үүргийн давхардал, зөрчил, хийдлийн талаар
- Дүгнэлт

Ашигт малтмалын тухай хуулийн үзэл баримтлал, өөрчлөлт, чиг хандлага

- Ашигт малтмалын тухай хуулийг анх 1997 онд баталж, 2006 онд шинэчлэн батлалсан.
- Ашигт малтмалын тухай хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- Ашигт малтмалын тухай хууль 11 бүлэг 66 зүйлээс бүрддэг.
- Уг хууль батлагдсанаас хойш нийт **32** удаагийн **300** төрлийн нэмэлт, өөрчлөлт орсон байна. Үүнээс:
  - ✓ Хуулийн зүйл, хэсэг, заалтад нэмэлт оруулсан **49**
  - ✓ Хуулийн зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт оруулсан **122**
  - ✓ Хуульд шинээр зүйл, хэсэг, заалт нэмсэн **78**
  - ✓ Хуулийн зүйл, хэсэг, заалтын агуулгыг өөрчлөн найруулсан **32**
  - ✓ Хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгосон **19**

Газрын тосны тухай хуулийн үзэл баримтлал, өөрчлөлт, чиг хандлага

- Газрын тосны тухай хууль анх 1991 онд батлагдаж байсан бөгөөд 2014 онд шинэчлэн баталсан.
- Уг хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосыг эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулдаг, 9 бүлэг 45 зүйлээс бүхий хууль.
- Уг хууль батлагдсанаас хойш нийт **4** удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон.

Ашигт малтмалын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн талаар

- ХЗДХС-ын 2017 оны А/67 дугаар тушаалаар Уул уурхайн салбарын хууль, тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хэсгийг байгуулж, холбогдох судалгааг 2 яамны албан хаагчид хамтран ажилласан.
- Эрдэс баялгийн салбарын 10 хуульд дүн шинжилгээ хийж нийт **267** давхардал, **150** зөрчил, **150** хийдэл тогтоосон. Үүнд:
  - ✓ **104** нь Ашигт малмалын тухай хуульд хамаарах бөгөөд тодруулбал, давхардсан **13**, хийдэлтэй **58**, зөрчилтэй **33** заалт,
  - ✓ 36 нь Газрын тосны тухай хуульд хамаарах бөгөөд давхардсан **1**, хийдэлтэй **19**, зөрчилтэй **16** заалт.

Давхардал, зөрчил, хийдлийг шийдвэрлэх зорилгоор: Ашигт малтмалын тухай хуульд 7 зүйл бүхий нэмэлт, өөрчлөлт оруулж, түүнтэй холбоотойгоор 9 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар;

Газрын тосны тухай хуульд 7 зүйл бүхий нэмэлт, өөрчлөлт оруулж, түүнтэй холбоотойгоор 1 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тус тус боловсруулсан.

№	Хуулийн нэр	Давхардал	Хийдэл	Зөрчил
1	Ашигт малтмалын тухай	13	58	33
2	Газрын тосны тухай	1	19	16
3	Газрын тосны бүтээгдэхүүний тухай	7	12	4
4	Газрын хэвлийн тухай	27	21	25
5	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малмал хайх, ашиглахыг хориглох тухай	2	4	2
6	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1	-	3
7	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай	212	11	17
8	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай	-	5	17
9	Цөмийн энергийн тухай	4	20	33
10	Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	-	-	-
	Нийт	**267**	**150**	**150**

Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай
- Газрын тухай
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай
- Түгээмэл тархайцтай ашигт малтмалын тухай
- Татварын ерөнхий хууль
- Дагаж мөрдөх журмын
- Урт нэртэй хууль

Газрын тосны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

Байгаль орчныг хамгаалах тухай

- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (6 зүйлээс бүрдэнэ);
- Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (7 зүйлээс бүрдэнэ);

Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР

- ✓ Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм;
- ✓ Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм;
- ✓ Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй байдлын дүрэм;
- ✓ Ашигт малтмалын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам;
- ✓ Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрэм;
- ✓ Тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх журам;
- ✓ Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих тухай журам;
- ✓ Монгол орны нутаг дэвсгэрт геологи, геохими, гидрогеологийн зураглал, геофизик, геоэкологи, минерагени, металлогений судалгаа болон төрөл бүрийн ашигт малтмалын хайгуулын ажлыг гүйцэтгэх зааврууд.

Дагалдах бусад хуулийн хувьд

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үүсээд буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх үүднээс 2014 онд батлагдсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болгож, уг хууль хүчингүй болсонтой холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулаад байна.

Чиг үүргийн давхардал, зөрчил, хийдлийн талаар

- Хяналт шалгалтын чиг үүргийн давхардал
- Эрх хэмжээний давхардал

Мэргэжлийн хяналтын байгууллага нь ашигт малтмалын үйл ажиллагаанд улсын хяналтын үүрэг гүйцэтгэдэг /АМтХ-ийн §11.3/ харин геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих /АМтХ-ийн §10.1.1, §10.1.8/чиг үүрэгтэй. Гэвч, Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн шаардлагаар улсын байцаагчийн эрхгүй бол хяналт хийх эрхгүй болж байгаа нь чиг үүргийн давхардал нь хууль хоорондын зөрчлийг үүсгэж байна

Манай хуулийн төсөлд энэ асуудал тусгагдаагүй боловч зайлшгүй хийгдэх ёстой.

Чиг үүргийн давхардал, зөрчил, хийдлийн талаар

Мөн“АМтХ-ийн **42.4.Стратегийн ач холбогдол бүхий ордын** ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар энэ хуулийн 42.1-д заасан гэрээг **аймаг, нийслэлийн Засаг даргатай** байгуулна. Стратегийн ач холбогдол бүхий ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тус гэрээг **сум, дүүргийн Засаг даргатай** байгуулна.”

Чиг үүргийн давхардал, зөрчил, хийдлийн талаар

42 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах.

42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар **нутгийн захиргааны байгууллагатай** гэрээ байгуулж ажиллана.

42.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.

42.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.

Хэнтэй байгуулах нь хийдэлтэй байна.

- 2014 онд шинэчлэн батлагдсан Газрын тосны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ыг УИХ батлахаар байдаг. Гэтэл 2015 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т Засгийн газар батлахаар заасан байна. Иймд дээрх хуулиудын зөрчлийг арилгах үүднээс Газрын тосны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг батлах гэснийг хасахаар Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

- Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийг зарцуулах, сургалтын урамшууллыг зарцуулах” гэсэн журмуудыг батлахаар тусган оруулаа. Эдгээр журмуудыг баталж мөрдүүлснээр төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн мөнгөн хөрөнгийг зарцуулах эрх зүйн орчин тодорхой болж, зарцуулалт нь ил тод болно. Сургалтын урамшууллыг зарцуулах журам батлагдсанаар газрын тосны салбарын мэргэжлийн хүний нөөц үе шаттайгаар нэмэгдэж, гадаадаас авах ажиллах хүчний тоо буурах юм.

- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд газрын тосны бүтээгдэхүүн болох шатахуун, шатдаг хий, тусгай шингэний нэр томъёог тодорхойлон оруулж байгаа бөгөөд ийнхүү тодорхойлсноор шатахууны импорт, бөөний болон жижиглэнгийн худалдааны тусгай зөвшөөрөл олголт болон газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, импорт зэрэг үйл ажиллагааны нэршил, зохицуулалт ойлгомжтой болно.

- Хэрэглэгчдийг чанартай шатахуунаар хангах үүднээс чанарын хяналт тавих эрхийг төрийн захиргааны байгууллагад олгохоор хуулийн төсөлд тусгасан бөгөөд энэ нь хэрэглэгчдийг чанарын баталгаатай газрын тосны бүтээгдэхүүнээр хангах, газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог бий болгоход эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

- Газрын тосны бэлэн болон завсрын бүтээгдэхүүний тодорхойлолтыг хуулийн төсөлд шинээр тусган завсрын бүтээгдэхүүний импорт, худалдаа, үйлдвэрлэлийн зохицуулалтыг нэмснээр чанарын шаардлага хангаагүй газрын тосны бүтээгдэхүүнийг худалдах асуудлыг цэгцлэх зорилготой болно.
- Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд зохицуулах шаардлагатай боловч батлах эрх олгогдоогүй шатдаг хий, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, чанарын хяналт, мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор дараахь журмыг батлах, мөрдүүлэх эрхийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгохоор хуулийн төсөлд тусгаад байна. Үүнд:

- ✓ Шатдаг хийн импорт, худалдаа, тээвэрлэлт, түгээлт, хадгалалтын үйл ажиллагааг зохицуулах журам баталж мөрдүүлэх;
- ✓ Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам баталж мөрдүүлэх;
- ✓ Газрын тосны бүтээгдэхүүний чанарт хяналт тавих журам баталж, мөрдүүлэх;
- ✓ Газрын тосны бүтээгдэхүүний мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм баталж мөрдүүлэх зэрэг болно.

- Газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар санал, дүгнэлт гаргах зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний мэргэжлийн зөвлөл байгуулах талаар хуулийн төсөлд тусгав.
- Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн холбогдох зүйл заалтуудын үг үсгийн алдаа ишлэлийг засч, орхигдуулсан нэр томъёог нэмж оруулсан бөгөөд Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал боловсруулан тусгалаа.



ДҮГНЭЛТ

Дүгнэлт

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулснаар Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдэл арилж, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд, орон нутгийн иргэд төдийгүй төрийн байгууллагын түвшинд үүсээд байдаг хүндрэлтэй асуудлууд шийдэгдэнэ. Мөн эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжуудын хийдэл, зөрчил, давхардлыг арилгаснаар ил тод, хариуцлагатай уул уурхайн тогтолцоог олон улсын чиг хандлагад нийцүүлэхэд чухал алхам болох юм.



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА